



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 4/91

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сайншандын өнгөрөлтийн цэгийн байрны харуул хамгаалалт", "Бөмбөгөр радиолокаторын байрны харуул хамгаалалт", "Сайхандулаан радиолокаторын байрны харуул хамгаалалт", "Баянтээг радиолокаторын байрны харуул хамгаалалт", "Их-Өлгий радиолокаторын байрны харуул хамгаалалт", "Бор-Өндөр радиолокаторын байрны харуул хамгаалалт", болон "Хэнгэрэгтэй радиолокаторын байрны харуул хамгаалалт"-ын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Г.Баттөгс

(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Холбоо,
навигаци, ажиглалтын албаны дарга)

Гишүүд:

О.Эрхэмбаяр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Холбоо,
навигаци, ажиглалтын албаны Ажиглалт,
автоматжуулалтын хэсгийн Радиолокаторын
тасгийн ахлах инженер)

М.Пүрэвсүрэн

("Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв" Төрийн бус
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

П.Лхагважав
("ХУД Яармаг" Төрийн бус байгууллагын гишүүн
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн
дарга:

Ч.Ганзориг
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Г.Баттөгс)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА